

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 10

д/д		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Сэргэлэн сум, Төв аймаг	
				Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Хугацаа /I-IV улирал/	Хугацаа /I-IV улирал/	Хугацаа /I-IV улирал/		
		1	2	3	4	5	6	7		
		Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.3), (Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2.5.2, 2.7.5), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3, 4, 5, 6, дугаар зорилт)								
		Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт								
		Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.								
1		Арга хэмжээ 1.1. Гадаадын иргэнд олгох Монгол Улсын визийн үйлчилгээ, бүртгэл, хяналтыг зохион байгуулах	Зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний хувь			Тайлант хугацаанд нийт 56 орны 1971 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс: Нэг удаагийн орох – 1789 Хоёр удаагийн орох - 59 Олон удаагийн орох – 123 Цахим визийн 3005 хүсэлтийг хүлээн авч шалгаснаас 41 иргэний хүсэлтийг холбогдох байгууллагаас санал авахаар шилжүүлж, 2961 иргэнд зохих ангиллын цахим визийг олгож, 3 иргэн виз олгохоос татгалзсан. Тайлант хугацаанд түр ирэгчийн хасалт 25 орны 133 гадаадын иргэнд, оршин суух зөвшөөрөлтэй 13 орны 109 гадаадын иргэний оршин зөвшөөрлийн хасалт хийсэн байна. Мөн цахимаар визийн сунгалт болон оршин суух зөвшөөрлийн хасалт хийлгэсэн 96 гадаадын иргэнд бүртгэсэн хүртэл тэмдэг дарж гаргасан.	100	100	I-IV	
2		Арга хэмжээ 1.2. Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр	Зөвлөгөө мэдээллийн хэлбэр, иргэнд	2/3741	2/3741-өөс доошгүй	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчлах танин мэдүүлэх	I-IV			

	1	2	3	4	5	6	7
	иргэдийг мэдээллээр хангах зөвлөгөө, зөвлөгөө, хангах	үйлчилгээ хүргэсэн тоо			зорилгоор биечлэн 1286, утсаар 1530 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.		
3	Арга хэмжээ 1.3. Төв аймгийн нутаг дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Тайлант хугацаанд Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр баталсан 11/01 дугаартай "Хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд "Чингис хаан" олон улсын нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй агаарын тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд болон тэдгээрийн төлөөлөгчийн газрын удирдах албан тушаалтан, ажиллаж буй гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөл нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийсэн. Тухайн шалгалтыг агаарын замын боомт хариуцсан газрын дөрвөн эзлэгийн 17 эрх бүхий албан тушаалтан хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтад гадаад, дотоодын 6 авиа компани, 13 төлөөлөгчийн газар, 1 нисэх буудлын сургалтын төв хамрагдаж 8 орны 35 гадаадын иргэний виз, оршин суух зөвшөөрөлд хяналт шалгалт хийсэн байна. Хяналтын шалгалтын хүрээнд виз, оршин суух зөвшөөрөлтэй холбоотой аливаа зөрчил дутагдал илрээгүй. Шалгалтад хамрагдсан 20 аж ахуйн нэгж байгууллагыг объектын судалгаанд бүртгэж, баяжилт хийсэн. Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр баталсан 11/02 дугаар "Визгүй зорчих иргэдэд тавих хяналтыг эрчимжүүлэх шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд "Чингис хаан" олон улсын агаарын замын боомтоор зорчигч гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, визгүй зорчигч буй иргэдийн Монгол Улсад нэвтрэх зорилго нь тухайн улстай байгуулсан санамж бичиг, хэлэлцээр, визийн	I-IV	

1	2	3	4	5	6	7
				шаардлагаас чөлөөлсөн нөхцөлд нийцэж буй эсхийг ярилцлагаар тогтоож ажилласан. Шалгалтын хүрээнд нийт 7 орны 231 иргэнтэй ярилцлага хийж 88 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтлан улсын хил нэвтрүүлэггүй буцаах арга хэмжээг авч ажилласан. Шалгалтын ажиллагаа үргэлжилж байна. Байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1-05/08 дугаартай "Хяналт шалгалтаар ажиллах тухай" удирдамжийн хүрээнд төв аймгийн нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын иргэд ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийсэн. Уг хяналт шалгалтын ажлын хүрээнд 27 аж ахуйн нэгж байгууллагын 1438 иргэний бичиг баримтыг шалгасан. Шалгалтаар БНХАУ-ын 3 иргэн нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн, БНХАУ-ын 3 иргэн ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан зөрчлийг илрүүлж Монгол Улсаас албадан гархааар ажиллаж байна. Мөн 6 аж ахуйн нэгж байгууллагад хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Шалгалтад хамрагдсан ААНБ-ыг объектын судалгаанд бүртгэж, баяжилт хийх ажиллагаа үргэлжилж байна. "ISM" системээс давхардсан тоогоор 26,798 гадаадын иргэний "F8" мэдээллийг шалгаж, зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем /Apis"/-д бүртгэгдсэн 10,297 иргэний мэдээлэлд тулгалт хийж ажилласан.		
4	Арга хэмжээ 1.4. Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэн, уригчийн зөрчлийг шийдвэрлэх	Зөрчил шийдвэрлэсэн хувь	100	Зөрчлийн тухай хуулийн дагуу уригч байгууллагаар 62 байгууллагын 71 гадаадын иргэн, гадаадын 15 орны 85 иргэн, 3 уригч иргэний урьсан 3 иргэнд арга хэмжээ авч нийт	I-IV	

1	2	3	4	5	6	7
Арга хэмжээ 1.5. Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан хувь			152 зөрчил шийдвэрлэж 34.710.000 төгрөгийн торгууль оногдуулсан.		
5		100	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр нийт 9 орны 40 иргэн (Узбекистан-2, Япон-1, Филиппин-2, Киргизстан-2, Хятад-3, Иран-1, Армен-1, Азербайжан-1, Того-1)-ийг Монгол Улсаас албадан гаргах дүгнэлт үйлдэн, байгууллагын даргын шийдвэрийн дагуу Монгол Улсаас албадан гаргасан. Төвөөс албадан гаргаж буй 13 орны 40 иргэнийг албадан гаргах ажиллагааг зохион байгуулж, албадан гаргасан тухай тодорхойлолтыг Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн.	I-IV	
6	Арга хэмжээ 1.6. Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавьж, хуульд заасан үндэслэлээр хил нэвтрүүлэлгүй буцаах	Эрх хязгаарласан болон бусад үндэслэлээр гадаадын иргэнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хувь	100	Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавих ажлын хүрээнд 287 гадаадын иргэнтэй ярилцлага хийснээс: - Хил нэвтрүүлэггүй буцаасан: - орох чиглэлд-103, гарах чиглэлд-16; - Баталгаа гаргуулсан - 19	I-IV	
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт						
Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ						
7	Арга хэмжээ 2.1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгаа хангах 2024 оны төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг бүтэн жилээр оны эцэст тайлагнана.	I-IV	
8	Арга хэмжээ 2.2. Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг бүтэн жилээр оны эцэст тайлагнана.	I-IV	

	1	2	3	4	5	6	7
9	Арга хэмжээ 2.3 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний эхний хагас жилийн биелэлт, мөн Гадаадын иргэн, харьяатын газрын авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг тус тус гарган Захиргаа, удирдлагын газарт 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 11/33 дугаар дотоод албан бичгээр хүргүүлсэн. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирсэн өргөдөлгүй, албан хаагчдаас 6 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 3 өргөдлийг харьяаллын дагуу төв руу шилжүүлж, 3 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.	I-IV	
10	Арга хэмжээ 2.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэлтийн хувь	100	100		I-IV	
11	Арга хэмжээ 2.5. Төсвийн шууд захирагчийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	Хэрэгжилтийн хувь	100	100	Төсвийн шууд захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын 2024 оны төсвийг батлуулсан бөгөөд төсвийг зардлын дагуу зарцуулан, өр, авлагагүй ажиллаж байна.	I-IV	
12	Арга хэмжээ 2.6. Төсвийн шууд захирагчийн тайлан балансыг гарган, санхүүгийн аудит хийлгэж, тайлбар гаргах	Зөвлөмж, акт, албан шаардлага авсан эсэх (өсөлт, бууралт)	0	0	Агаарын замын боомт хариуцсан газрын 2023 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас 2024 оны 03 дугаар сард аудит хийн зөрчилтэй дүгнэлт авсан.	I-IV	
13	Арга хэмжээ 2.7. Тэмдэгтийн хураамжийн орлого, хүү торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, холбогдох тайлан гаргах	Орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хувь	100	100	2024 оны эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 560,079,988 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн төлбөр, 81,018,463 төгрөгийн үйлчилгээний хураамжийн төлбөр, 34,990,000 төгрөгийн хүү торгуулийн орлого, нийт 676,088,451 төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж, аймгийн болон төвийн татварын орлогын дансанд шилжүүлсэн	I-IV	
14	Арга хэмжээ 2.8.	Шилэн дансанд оруулсан	152/100	152/100	Шилэн дансны хуульд заасны дагуу: - Тухай бүр мэдээлэх 10 төрлийн 30 мэдээ;	I-IV	

	1	2	3	4	5	6	7
	Төсвийн шууд захирагчийн төсөвтэй холбоотой мэдээ, тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	мэдээллийн тоо, хангасан хувь			- Сар бүр мэдээлэх 4 төрлийн 12 мэдээ; 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 42 мэдээг хуулийн хугацаанд цахим сайтад байршуулсан.		
15	Арга хэмжээ 2.9. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан тэнцлийг гаргах	Тооллогын тоо, тооцоо нийлсэн акт	2	2	Тус газрын 2024 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хийх тухай газрын даргын А/05 тушаал батлагдсан бөгөөд дүнг 06 дугаар сарын 25-ны өдөр танилцуулагдана.	II, IV	
16	Арга хэмжээ 2.10. Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах	Тавилга, тоног төхөөрөмжийн тоо	-	2/50	Төв аймгийн Зуун мод сумын хөрөнгө оруулалтаар 34,896,800,00 төгрөгийн үнэ бүхий 37 ш тавилга авсан.	I	

-----oOo-----

Гадаадын иргэн, харьяатын газрын
Агаарын замын боомт хариуцсан газрын
2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
хавсралт

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
1	Монгол бичгийн сургалтад хамрагдах	Сертификат авсан байна	-	Эхний хагас жилд сургалтад хамрагдаж, сертификат авсан байна	Удирдлагын академийн цахим сургалтад хамрагдаж, Монгол бичгийн ахисан шатны цахим хичээл 3 дугаар шатад суралцан, сертификат авсан. Үнэмлэхийн дугаар: nti4kevza1	03-05	
2	Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад хамрагдах	Сертификат авсан байна	-	Сүүлийн хагас жилд сургалтад хамрагдаж, сертификат авсан байна	Хугацаа болоогүй	08-10	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨХ

З.ӨНӨРСАЙХАН

ТАЙЛАГНАСАН:

АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА,
ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨХ

З.Даваасүрэн

З.ДАВААСҮРЭН

2024 оны 06 сарын 10

2024 оны 06 сарын ...

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 04

Гүйцэтгэлийн түвшин							Сэргэлэн сум, Төв аймаг	
д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Хугацаа I-IV улирал/	Биелэлт ийн хувь	
	1	2	3	4	5	6	7	
	Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.3), (Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын үндсэн асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2.5.2, 2.7.5), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3, 4, 5, 6, дугаар зорилт)							
	Зорилт 1. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна.							
1	Арга хэмжээ 1.1. Гадаадын иргэнд олгох Монгол Улсын визийн үйлчилгээ, бүртгэл, хяналтыг зохион байгуулах	Зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний хувь	100	100	Тайлант хугацаанд 6606 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс: Нэг удаагийн орох – 5882 Хоёр удаагийн орох - 343 Олон удаагийн орох – 364 Хүчингүй болгосон – 11 Визийн засвар – 5 Шилжүүлэг - 1 Цахим визийн 11494 хүсэлтийг хүлээн авч шалгаснаас 93 иргэний хүсэлтийг холбогдох байгууллагаас санал авахаар шилжүүлж, 11389 иргэнд зохих ангиллын цахим визийг олгож, 12 иргэнд виз олгохоос татгалзсан. Тайлант хугацаанд түр ирэгчийн хасалт 683 гадаадын иргэнд, оршин суух зөвшөөрөлтэй 204 гадаадын иргэний оршин зөвшөөрлийн хасалт хийсэн байна. Мөн цахимаар визийн сунгалт болон оршин суух зөвшөөрлийн хасалт хийлгэсэн 261 гадаадын иргэнд бүртгэсэн хүртэл тэмдэг дарж гаргасан.	I-IV		

	1	2	3	4	5	6	7
2	Арга хэмжээ 1.2. Гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах	Зөвлөгөө мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо	2/3741	2/3741-өөс доошгүй	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж сурталчлах танин мэдүүлэх зорилгоор биечлэн 3312, утсаар 3777, нийт 7089 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	I-IV	
3	Арга хэмжээ 1.3. Төв аймгийн нутаг дэвсгэрт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 5, нийт 8 хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар 71 аж ахуйн нэгж, байгууллагын 1605 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 42 зөрчлийг илрүүлэн 42 зөрчилд торгох шийтгэл оногдуулж, 28 иргэнийг албадан гаргаж, 6 аж ахуйн нэгж, байгууллагад албан шаардлага өгсөн байна.	I-IV	
4	Арга хэмжээ 1.4. Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэн, уригчийн зөрчлийг шийдвэрлэх	Зөрчил шийдвэрлэсэн хувь	100	100	Зөрчлийн тухай хуулийн дагуу уригч байгууллагаар 125 байгууллагын 160 гадаадын иргэн, гадаадын 42 орны 446 иргэн, 4 уригч иргэний урьсан 4 иргэний гаргасан зөрчилд арга хэмжээ авч нийт 575 зөрчил шийдвэрлэж 144,340,000 төгрөгийн торгууль оногдуулсан.	I-IV	
5	Арга хэмжээ 1.5. Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Шийдвэрийг хэрэгжүүлж ажилласан хувь	100	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан үндэслэлээр 76 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах дүгнэлт үйлдэн, байгууллагын даргын шийдвэрийн дагуу Монгол Улсаас албадан гаргасан.	I-IV	
6	Арга хэмжээ 1.6. Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэний	Эрх хязгаарласан болон бусад үндэслэлээр	100	100	Төвөөс албадан гаргаж буй 114 гадаадын иргэнийг албадан гаргах ажиллагааг зохион байгуулж, албадан гаргасан тухай тодорхойлолтыг Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлсэн.	I-IV	
					Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавих ажлын хүрээнд 1181 гадаадын иргэнтэй ярилцлага хийснээс.	I-IV	

1	2	3	4	5	6	7
хөдөлгөөнд хяналт тавьж, хуульд заасан үндэслэлээр хил нэвтрүүлэлгүй буцаах	гадаадын иргэнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хувь			- Хил нэвтрүүлэлгүй буцаасан - 529; (орох чиглэлд-517, гарах чиглэлд-12) - хил нэвтрүүлсэн 652;		
Зорилт 2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт						
Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ						
Арга хэмжээ 2.1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь			Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгаа хангах 2024 оны төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал тайлант хугацаанд: - "Мон медикал" клиникийн эмнэлэгт тус газрын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулж, газраас нэг албан хаагчид 100,000 төгрөгийн үнэ бүхий багц үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлсэн. Эрүүл мэндийн үзлэгт нийт 22 албан хаагч хамрагдсан; - 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Агаарын замын боомт хариуцсан газрын 22 албан хаагчдад 58,065,744.84 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон.; - Чингис хаан олон улсын агаарын замын боомтод үүрэг гүйцэтгэж буй ээлжийн албан хаагчид болон захиргааны албан хаагчдыг Хьюндай Старекс, Ниссан Урбан албаны унаагаар хүргэж өгөх, авах ажлыг зохион байгуулж байна; - Газрын даргын 2024 оны Б/068 Б/09, Б/10 дугаар тушаалаар сахилга, ёс зүйн шийтгэлгүй, улирын ажлын дүнгээр "Маш сайн", "Хэвийн" үнэлүүлсэн албан хаагчдад 55,670,200 төгрөгийн үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. Газрын даргын 2024 оны Б/02, Б/03, Б/05, Б/07, Б/11 дүгээр тушаалаар төрийн үйлчилгээний давхардсан тоогоор 8 албан хаагчдад		
7		100	100		I-IV	

1	2	3	4	5	6	7
				1,774,770.46 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон. - 2022 оны А/66 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7.4.1-д заасан үндэслэлээр 3 албан хаагчид 1,870,000 төгрөгийн мөнгөн тусламжийг олгосон. Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний биелэлт, "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн 2024 оны хэрэгжилтийн хүснэгтэн тоон мэдээлэл болон Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийг сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний биелэлтийг тус тус гаргаж 2024.11.15-ны өдрийн 11/82 дугаар дотоод албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал төлөвлөгөөнд заагдсан ажлын хүрээнд: - Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зориулсан "Монгол бичиг" цахим сургалтад тус газрын давхардсан тоогоор 34 албан хаагч суралцаж 19 албан хаагч Монгол бичгийн анхан шатны цахим хичээл 1-р шат, 12 албан хаагч 2-р шат, 3 албан хаагч 3-р шатны сургалтыг амжилттай судлан, үнэмлэх авсан;		
8	Арга хэмжээ 2.2. Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV	

1	2	3	4	5	6	7
				- Төвөөс байгууллагын сургалтын төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээний дагуу зохион байгуулсан 13 удаагийн сургалтад газрын албан хаагчид цахимаар хамрагдсан; - 2024.11.20-нд Захиргаа, удирдлагын газартай хамтран "Хүчирхийлэл дагуулсан экстремизм ба радикалчлалын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх" сэдвээр Тагнуулын ерөнхий газраас цахимаар сургалт авсан. Цахим сургалтад тус газраас 19 албан хаагч хамрагдсан; - 2024.11.24-нд Хил хяналтын байгууллагуудын захиргааны нэгдсэн байрны сургалтын танхимд "Чагнуур эмч мэргэжилтнүүдийн нийгэмлэг" ТББ-ын сургагч багш нар "Анхны тусламж" сэдвээр 3 цагийн сургалт орсон. Сургалтад тус газрын 21 албан хаагч танхимаар хамрагдсан. Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөний Агаарын замын боомт хариуцсан газартай холбоотой биелэлтийг гаргаж 2024.11.15-ны өдрийн 11/82 дугаар дотоод албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн.		
9	Арга хэмжээ 2.3 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	I-IV	

1	2	3	4	5	6	7
				Тайлант хугацаанд албан хаагчдаас гэрээ байгуулах, хяналт шалгалт хийхдээ холбогдуулан нийт 46 "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг хүлээн авч, цахим системд бүртгэсэн. Газрын албан хаагчдын 2023 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, тус газрын хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад зөвлөгөө, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн бөгөөд 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар төрийн захиргааны 25, төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягтыг хүлээн авч, хяналт тавин ажилласан. Мөн тус газарт шилжин томилогдсон 3 албан хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, баталгааны маягтыг хүлээн авч, цахим системд бүртгэсэн. Авлига, албан тушаалтай холбоотой гомдлыг мэдээлэх талаар олон нийтэд таниулах зорилгоор зурагт хуудас (постер) бэлдэж, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь тус газрын ирэгч, явагчийн өрөөнд байрлуулсан. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс 1 өргөдөл, албан хаагчдаас 14 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 5 өргөдлийг харьяаллын дагуу төв руу шилжүүлж, 10 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Төсвийн шууд захирагчийн урсгал болон хөрөнгө оруулалтын 2024 онд 1,832,462,100 төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар 1,406,684,902.26 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, өр, авлагагүй ажилласан. Агаарын замын боомт хариуцсан газрын 2023 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын		
10	Арга хэмжээ 2.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэлтийн хувь	100	100	I-IV	
11	Арга хэмжээ 2.5. Төсвийн шууд захирагчийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	Хэрэгжилтийн хувь	100	100	I-IV	
12	Арга хэмжээ 2.6.	Зөвлөмж, акт, албан шаардлага	0	0	I-IV	

	1	2	3	4	5	6	7
	Төсвийн шууд захирагчийн тайлан балансыг гарган, санхүүгийн аудит хийлгэж, тайлбар гаргах	авсан эсэх (өсөлт, бууралт)			газраас 2024 оны 03 дугаар сард аудит хийн 4 зөвлөмж, 1 төлбөрийн акт авсан. Зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг 11/47 тоот албан бичгээр болон fas.audit.mn цахим хуудаст байршуулсан.		
13	Арга хэмжээ 2.7. Тэмдэгтийн хураамжийн орлого, хүү торгуулийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, холбогдох тайлан гаргах	Орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хувь	100	100	2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 1,830,396,422.79 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн төлбөр, 241,376,089.63 төгрөгийн үйлчилгээний хураамжийн төлбөр, 134,380,000 төгрөгийн хүү торгуулийн орлого, нийт 2,206,152,512.42 төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж, аймгийн болон төвийн татварын орлогын дансанд шилжүүлсэн	I-IV	
14	Арга хэмжээ 2.8. Төсвийн шууд захирагчийн төсөвтэй холбоотой мэдээ, тайланг холбогдох албан байгууллага, тушаалтанд хүргүүлэх	Шилэн дансанд оруулсан мэдээллийн тоо, хангасан хувь	152/100	152/100	Шилэн дансны хуульд заасны дагуу: - Тухай бүр мэдээлэх 10 төрлийн 110 мэдээ; - Сар бүр мэдээлэх 4 төрлийн 44 мэдээ; - Хагас жил бүр мэдээлэх 4 төрлийн 4 мэдээ; - Жил бүр мэдээлэх 5 төрлийн 5 мэдээ; 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар нийт 163 мэдээг хуулийн хугацаанд цахим сайтад байршуулсан.	I-IV	
15	Арга хэмжээ 2.9. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлан тэнцлийг гаргах	Тооллогын тоо, тооцоо нийлсэн акт	2	2	Тус газрын 2024 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хийх тухай газрын даргын 2024 оны А/05 тушаал батлагдсан бөгөөд тооллогын дүнг газрын даргад 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 11/41 дүгээр илтгэх хуудсаар танилцуулж, төвийн тооллогын комисст хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн тооллогын 12 дугаар сарын сүүлээр хийгдэнэ.	II, IV	
16	Арга хэмжээ 2.10. Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах	Тавилга, тоног төхөөрөмжийн тоо	-	2/50	Төв аймгийн Зуун мод сумын дэмжлэгээр 34,896,800.00 төгрөгийн үнэ бүхий 41 ш тавилга, 40,899,080 төгрөгийн үнэ бүхий 18 ш тоног төхөөрөмж, нийт 75,795,880 төгрөгийн үнэ бүхий 59 ширхэг тавилга, тоног төхөөрөмжийг хүлээн авсан.	I	

Гадаадын иргэн, харьяатын газрын Агаарын замын боомт хариуцсан газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
1	Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад хамрагдах	Сертификат авсан байна	-	Сүүлийн хагас жилд сургалтад хамрагдаж, сертификат авсан байна	Удирдлагын академийн "Ёс зүй" цахим сургалтын 1, 2-р түвшин, "Хүний эрх" цахим сургалтын 1-р түвшинд хамрагдан суралцаж, сертификат авсан. Үнэмлэхийн дугаар: xvtrwfr8wh, aep5kvtown, mw2cutbury	08-10	

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨХ

З.ӨНӨРСАЙХАН

2024 оны 12 сарын ...

ТАЙЛАГНАСАН:

АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА,
ЭРХЭЛСЭН ЗӨВЛӨХ

З.ДАВААСҮРЭН

2024 оны 12 сарын 04